

UCS 1403B : 2020

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ



Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног
төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт,
тоног төхөөрөмжид тавих
ерөнхий шаардлага



ГАРЧИГ

1. Зорилго	4
2. Хамрах хүрээ.....	4
3. Эшлэл авсан баримт бичгүүд	4
4. Нэр томьёо, тодорхойлолт.....	4
5. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	5
6. Талбайн хучилтад тавигдах ерөнхий шаардлага	5
7. Тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага.....	7
8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдал.....	8
9. Статик тоног төхөөрөмж.....	9
10. Динамик тоног төхөөрөмж.....	10
11. Тоног төхөөрөмж байрлуулах	10
12. Тоног төхөөрөмжийг суурилуулах	12
13. Тоног төхөөрөмжийн материалд тавигдах шаардлага	13
14. Тоног төхөөрөмжийг ашиглах заавар болон мэдээллийн хэсэг	13
15. Чийрэгжүүлэх талбай нэмэлт тоноглол	15
16. Ашиглалт, засвар үйлчилгээ, хяналт	16
17. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар	17
18. Чийрэгжүүлэх талбайн шалгуур үзүүлэлт	19
Ашигласан материалын жагсаалт	20

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Талбайн давхаргын зузааны зохистой хэмжээ	6
Хүснэгт 2. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төрөл /зориулалтаар/	8
Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон дасгалын орон зай	11
Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн хяналт, үнэлгээ хийх үзүүлэлт	16
Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлт	19

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хөдөлгөөний болон тоног төхөөрөмжийн орон зай	7
Зураг 2. Хүзүү, нугасанд ачаалал өгөх.....	7
Зураг 3. Нуруу, нугасанд ачаалал өгөх	7
Зураг 4. Олон талт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан чийрэгжүүлэх тоног төхөөрөмж.....	9
Зураг 5. Статик тоног төхөөрөмж	9
Зураг 6. Динамик тоног төхөөрөмж	10
Зураг 7. Түгжээ, холбогч, хамгаалалт ба, ил гарсан хэсгийн зөвшөөрөгдсөн хэмжээ /мм-ээр/	12
Зураг 8. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн суурилуулалтын жишиг зураг.....	13
Зураг 9. Тоног төхөөрөмж дээрх санамж, мэдээллийн хэсэг	14
Зураг 10. Хэрэглэгчдэд зориулсан талбайн мэдээллийн самбар	14
Зураг 11. Нэмэлт гэрэлтүүлэг бүхий чийрэгжүүлэх талбай	15
Зураг 12. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар-1	17
Зураг 13. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар-2	17
Зураг 14. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-1	17
Зураг 15. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-2	18
Зураг 16. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-3	18
Зураг 17. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-4	18
Зураг 18. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-5	18

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавигдах ерөнхий шаардлага

1. ЗОРИЛГО

- 1.1. Энэхүү баримт бичгийн зорилго нь хүн амын эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа чийрэгжүүлэх, идэвхтэй амьдралын хэв маягийг бий болгоход зориулсан гадна чийрэгжүүлэх талбай байгуулах, ашиглах үйл ажиллагаанд нэгдсэн арга зүйн удирдамж өгч, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, оршин суугчдын эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангахад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Энэхүү баримт бичгийг нийтийн зориулалттай гадна чийрэгжүүлэх талбайг төлөвлөх, зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, талбайг шинэчлэн засварлах, тоног төхөөрөмж суурилуулах, ашиглах, хяналт тавих үйл ажиллагаанд хэрэглэнэ.
- 2.2 Энэхүү баримт бичиг нь хүүхдийн тоглоомын талбайд хамаарах зүйлсийг зохицуулахгүй болно.

3. ЭШЛЭЛ АВСАН БАРИМТ БИЧГҮҮД

- 3.1 Энэхүү баримт бичигт дараах эш татсан БНБД болон стандартыг хэрэглэнэ. Эш татсан БНБД, стандартад өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

БНБД 3.01.06-90 Барилгын орчны тохижилтын ажил

БНБД 30.01.03 Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм

4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 **Чийрэгжүүлэх талбай** – нийтийн эзэмшлийн талбайд олон нийт чөлөөт цагаа зөв, боловсон өнгөрүүлэх, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, бие бялдраа хөгжүүлэх, спортоор хичээллэх боломж олгох зориулалт бүхий тоног төхөөрөмжөөр тоноглогдсон талбайг;
- 4.2 **Ашиглалтын хэсэг** – дасгал хийгдэж буй төхөөрөмжийн хэсэг, хэсэглэл;
- 4.3 **Хөдөлгөөний орон зай** – чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн орчны хязгаарлалтын шинж чанарыг харуулсан орон зай;
- 4.4 **Дасгалын орон зай** – дасгал хийхэд шаардлагатай орон зай;
- 4.5 **Динамик тоног төхөөрөмж** – хөдөлгөөнт хэсэглэлүүдтэй тоног төхөөрөмжийг;
- 4.6 **Статик тоног төхөөрөмж** – үл хөдлөх, хөдөлгөөнгүй хэсэглэлтэй тоног төхөөрөмжийг;
- 4.7 **Чөлөөт уналтын өндөр** – тоног төхөөрөмжийн хамгийн доод хэсэг буюу гадаргуугаас тоног төхөөрөмжийн хамгийн дээд цэг хүртэлх хоорондын өндрийн зай;


5. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 5.1 Чийрэгжүүлэх талбайг шинээр болон шинэчлэн төлөвлөхдөө иргэдийн эрүүл аюулгүй, тав тухтай орчинд дасгал, идэвхтэй хөдөлгөөнийг хийх нөхцөл бололцоог хангаж, гудамж талбайн тохижилт, инженерийн байгууламж зэрэгтэй уялдуулан төлөвлөнө.
- 5.2 Гадна талбайн чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг цэцэрлэгт хүрээлэн, орон сууцны хорооллын ногоон бүсэд болон нийтийн эзэмшлийн талбайд төлөвлөн байршуулна.
- 5.3 Чийрэгжүүлэх талбайд эзлэх хувийн жин болон нэг хүнд ногдох талбайн стандарт хэмжээ заахгүй бөгөөд чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг хүн амын хэрэгцээ, шаардлага, тухайн бүс нутгийн хүн амын нягтаршил зэргийг тооцсоны үндсэн дээр аль байршилд хэдий хэмжээний тоног төхөөрөмж байрлуулахыг нарийн төлөвлөнө.
- 5.4 Тоног төхөөрөмжийг олон нийт нийтээрээ хэрэглэх бөгөөд бүхий л цаг үед чөлөөтэй ашиглах боломжтой байна.
- 5.5 Чийрэгжүүлэх талбайн зах хэсэгт амрах, суух зориулалт бүхий нийтийн эзэмшлийн сандал, хогийн сав байршуулж болно.
- 5.6 Гудамж, гадна орчин, барилга байгууламжийн загвар, дизайн, өнгө үзэмжид нөлөөлөх, аюулгүй байдлыг хангах үүднээс гудамж, талбайн гэрэлтүүлгээс гадна чийрэгжүүлэх талбайд нэмэлт гэрэлтүүлэг суурилуулж болох ба гэрэлтүүлэг нь энгийн болон чимэглэлийн байж болно.
- 5.7 Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж бүхий дасгалын талбай нь бага насны хүүхэд болон 1400 мм-ээс доош өндөртэй хүнд зориулагдаагүй бөгөөд орчны аюулгүй байдал болон гэнэтийн эрсдэл, гэмтлийг тооцон эрсдэлийн /SWOT/ шинжилгээ хийж, судалгааны үр дүнд суурилан талбайн төлөвлөлтийг гаргах шаардлагатай.
- 5.8 Чийрэгжүүлэх талбайг хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэн нийтээрээ хэрэглэх боломжтой, олон талт тоног төхөөрөмжийг сонгон авч суурилуулна.
- 5.9 Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг албан ёсны үйлдвэрлэгч байгууллагаас авах ба тоног төхөөрөмж нь гарал үүслийн болон чанарын баталгааны гэрчилгээтэй байна.
- 5.10 Тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааварчилгаа, стандартын дагуу суурилуулан чанарын шаардлага хангасан байна.
- 5.11 Чийрэгжүүлэх талбайг дэд бүтэц болон гадна орчны тохижилттой уялдуулан төлөвлөх бөгөөд нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, гэрэлтүүлэг зэргийг батлагдсан зураг төслийн дагуу байрлуулна.
- 5.12 Чийрэгжүүлэх талбай, тоног төхөөрөмж нь хотын өнгө үзэмжид нийцсэн, орчин үеийн, шинэ, дэвшилтэд технологийн шийдлийг ашиглана.

6. ТАЛБАЙН ХУЧИЛТАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 6.1 Чийрэгжүүлэлтийн талбайн гадаргуу нь чөлөөт уналтын өндөр болон тоног төхөөрөмжийн төрлөөс хамааран хэрэглэгчдэд гэмтэл учруулахааргүй, аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангасан байна.
- 6.2 Чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмжийн төрөл болон чөлөөт уналтын хэмжээнээс хамааран гадаргуун материалын зузааныг тодорхойлно.
- 6.3 Чийрэгжүүлэлтийн талбайн гадаргуугийн зузааны хэмжээг Хүснэгт 1-т үзүүлэв.

Хүснэгт 1. Талбайн давхаргын зузааны зохистой хэмжээ

	Гадаргуугийн материал ^a	Тайлбар	Давхаргын зузааны ^a хэмжээ /мм/	Чөлөөт уналтын өндөр /мм/
1	Бетон/чулуун 	-	-	≤1000
2	Битум /цардмал/ 	-	-	≤1000
3	Зүлэг 	-	-	≤1500
4	Хөрс 	-	-	≤1200
5	Модны үртэс 	Зориулалтын дагуу механик аргаар буталсан мод. Модны холтос, навч байж болохгүй. 5 мм-ээс 30 мм-ийн ширхэглэлтэй байна.	200	≤ 2000
			300	≤ 3000
6	Ургамалын холтос, хальс 	Ургамал, модны төрлөөс хамаараад 20 мм-ээс 80 мм-ийн ширхэглэлтэй байна.	200	≤ 2000
			300	≤ 3000
7	Элс ^{b,c} 	0,2 мм-ээс 2 мм-ийн ширхэглэлтэй	200	≤ 2000
			300	≤ 3000
8	Хайрга ^{b,c} 	2 мм-ээс 8 мм-ийн ширхэглэлтэй	200	≤ 2000
			300	≤ 3000
9	Бусад материал ба давхаргын гүн	EN 1177 Н1С шалгуур, туршилтын дагуу	Шалгуур, туршилтын үндсэн дээр тооцно.	

^a Сул дүүргэх материалыг хамгийн бага давхаргын зузаан дээр 100 мм нэмнэ.


^b Шаварлаг хэсгүүд байж болохгүй бөгөөд EN 933-1 стандартын дагуу шигшсэн байна.

^c Хөдлөх хэсэг ихтэй, суурь, тулах цэг нь гүн, бат бэх байх шаардлагатай тоног төхөөрөмжид тохиромжгүй.

- 6.4 Чийрэгжүүлэх талбайн гадаргууг дасгал, хөдөлгөөн хийх үед тоног төхөөрөмжөөс унахад чөлөөт уналтаас үүсэх хүчийг сааруулах, багасгах, гэмтэл учруулахгүй байх зорилгоор талбайн гадаргуун материалыг сонгон хэрэглэнэ.
- 6.5 Хайрга, элс, үртэс зэрэг нөхөн сэргээж байх шаардлагатай гадаргуунууд нь тусгай арчилгаа шаарддаг бөгөөд өндөр ачаалалтай, нийтийн талбайд ойр ойрхон гадаргуун хяналт хийж засвар үйлчилгээ, нөхөн сэргээлтийг тогтмол хийж байх шаардлагатай.
- 6.6 Талбайн гадаргуу нь хэрэглэгч тээгэлдэх, бүдрэхээргүй тэгш, цэвэрлэхэд хялбар, хурц ирмэггүй, гогцоогүй байх ба гадаргуун засвар, арчилгааг тогтмол хийнэ.

7. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 7.1 Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж нь хэрэглэгчид зориулалтын дагуу ашиглахаар ойлгомжтой загвар хийц, угсралттай байна.
- 7.2 Тоног төхөөрөмж, хэрэгсэл, хэсэглэлийг зориулалтын бусаар ашиглах, дасгал хөдөлгөөнийг буруу гүйцэтгэсэн ч хэрэглэгчдэд ноцтой гэмтэл, хохирол учруулахгүй байхаар хийгдсэн байх шаардлагатай.
- 7.3 Тоног төхөөрөмж болон төхөөрөмжийн хэсэглэлд нуруу, хүзүүнд хэт ачаалал өгөх шахах төрлийн үйлдэлтэй төхөөрөмжийг хориглоно. Нуруу, хүзүүнд хэт ачаалал өгөх төхөөрөмж нь нурууны нугасыг гэмтээх, бэртээх аюултай.




1. Хөдөлгөөний орон зай
2. Дасгалын орон зай
3. Ашиглалтын хэсэг
4. Дасгалын давхацсан орон зай

Зураг 1. Хөдөлгөөний болон тоног төхөөрөмжийн орон зай



Зураг 2. Хүзүү, нугасанд ачаалал өгөх



Зураг 3. Нуруу, нугасанд ачаалал өгөх

7.4 Чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийн төрөл, ангиллыг Хүснэгт 2-т үзүүлэв.

7.5 Гадна талбайн чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг төрлөөр нь статик болон динамик мөн зориулалтаараа нь зогсох, хэвтэх, суух, зүүгдэх гэсэн дөрвөн төрөл ангилалтай байна.

Хүснэгт 2. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төрөл /зориулалтаар/

	Зогсож дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж		Сууж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж
	Хэвтэж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж		Зүүгдэж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж

7.6 Гадна талбайн чийрэгжүүлэх статик болон динамик тоног төхөөрөмжийг хамтад нь хослуулан байрлуулах боломжтой байдаг ба ингэснээр хэрэглэгчид нэг дор бүх төрлийн, иж бүрэн дасгал, хөдөлгөөнийг хийх боломжтой юм.

7.7 Статик болон динамик төрлийн тоног төхөөрөмжүүд нь ашиглалтын зориулалтаараа давуу болон сул талуудтай байдаг ба ашиглах явцад аюулгүй байдлыг хангах нь нэн чухал.

8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

8.1 Чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ, шаардлага, хүртээмжтэй байдлыг хангасан байх ба олон талт тоног төхөөрөмж байвал зохино.

8.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тоног төхөөрөмжийн загварыг Зураг 4-т үзүүлэв.



Зураг 4. Олон талт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан чийрэгжүүлэх тоног төхөөрөмж

9. СТАТИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Статик төрлийн тоног төхөөрөмж нь загвар хийцийн хувьд хөдлөх хэсэггүй байдаг бөгөөд тоног төхөөрөмж дээр чийрэгжүүлэлтийн бүхий л төрлийн дасгалуудыг хийх боломжтой.



Зураг 5. Статик тоног төхөөрөмж

Статик тоног төхөөрөмжийн давуу талууд:

- Нэг төрлийн тоног төхөөрөмж дээр олон төрлийн дасгалууд хийх боломжтой.
- Хөдлөх хэсэггүй учир хийгдэх засвар үйлчилгээ бага.
- Хэрэглэгдэх хугацаа урт, эдэлгээ их.
- Эвдрэл, гэмтэл багатай.
- Дасгал хөдөлгөөн хийхдээ нэмэлт хэрэгсэл (оосор, резин, уяа) ашиглах боломжтой.
- Бялдаржуулах дасгалаас гадна хүүхдүүд ч тоглох, дасгал хийх боломжтой.

Статик тоног төхөөрөмжийн сул тал:

- Статик тоног төхөөрөмж дээр ихэвчлэн өөрийн биеийн жингээр дасгал хөдөлгөөн хийдэг тул ахисан түвшний чадвар шаарддаг.
- Тоног төхөөрөмж дээр тухайн зориулалтын дасгал, хөдөлгөөнийг хийхэд ахисан түвшний чадвар шаарддаг нь анхан шатны болон шинэ хэрэглэгч төхөөрөмжийг ашиглахад хүндрэл учирдаг.
- Төхөөрөмжийг ашиглахад тогтсон дасгал, хөдөлгөөн, заавар байдаггүй учир зарим талаараа гэмтэх, бэртэх эрсдэл үүсгэх магадлалтай.

10. ДИНАМИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Динамик тоног төхөөрөмж нь хийцийн хувьд хөдлөх хэсгүүдтэй байх ба дасгал хийхэд хөдөлгөөн нь жигд, тогтмол, хөдөлгөөний хязгаартай байдаг.



Зураг 6. Динамик тоног төхөөрөмж

Динамик тоног төхөөрөмжийн давуу талууд:

- Динамик тоног төхөөрөмж нь дасгал, хөдөлгөөний хязгаарлалттай байдаг учир зориулалтын дагуу ашиглан гэмтэх, бэртэх эрсдэл бага байдаг.
- Тоног төхөөрөмж нь хэрэглэгчийн нас насны ангилалд тохирох сонголт ихтэй.
- Тухайн тоног төхөөрөмжийн дасгалыг хэрхэн яаж хийх нь ойлгомжтой байдаг.
- Хэрэглэхэд хялбар.
- Заавал мэргэжлийн болон нарийн чадвар шаардахгүй бөгөөд анхан шатны түвшний болон хүссэн хүн бүр ашиглах боломжтой.

Динамик тоног төхөөрөмжийн сул тал:

- Хэрэв хүүхдийн тоглоомын талбайн ойр динамик тоног төхөөрөмж байрлуулсан бол төхөөрөмж дээр хүүхэд тоглох, дасгал, хөдөлгөөний явцад оногдох, бэртэх, гэмтэх эрсдэлтэй.
- Цаг агаарын эрс, тэрс уур амьсгал нь динамик тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг багасгадаг бөгөөд засвар, үйлчилгээ их байдаг.
- Тоног төхөөрөмжийг хүний биеийн жин болон онцлогт тохируулан өөрчлөх боломжгүй байдаг.

11. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БАЙРЛУУЛАХ

11.1 Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг нийтийн эзэмшлийн гудамж, барилга байгууламж, орон сууцны гадна талбайд байрлуулах бөгөөд дараах хэм хэмжээг баримтална.





11.1.1 Чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмжийг хүүхдийн тоглоомын талбайн зэргэлдээ байрлуулах бол хүүхдийн аюулгүй байдлыг хангах, гарч болох гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлж хашлага, хашаа, хайсаар зааглана.

11.1.2 Авто зам, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэхээр төлөвлөж байгаа газарт байрлуулахгүй.

11.1.3 Чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмжүүд төрлөөсөө хамааран өөр өөр ашиглалтын болон дасгалын бүстэй байх ба тоног төхөөрөмжийн төрөл, зориулалтаас хамааран хоорондын зайг тооцож байрлуулна.


11.1.4 Тоног төхөөрөмжийн төрөл, зориулалтаар ашиглалтын болон дасгалын орон зайн хэмжээг Хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон дасгалын орон зай

Зориулалтын төрөл	Радиус /мм/	Өндөр /мм/
 Зогсох зориулалттай	1000	2200
 Суух зориулалттай	1000	1500 (суудлаас эхэлнэ)
 Зүүгдэх зориулалттай	500	2200 Заасан 2200 өндрөөс дээш багадаа 300 мм зайг нэмнэ. Тайлбар: Тоног төхөөрөмж нь нийт өндрөөс дээш багадаа 300 мм сул орон зайтай байна.
 Хэвтэх зориулалттай	1000	2200


12. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ СУУРИЛУУЛАХ

- 12.1 Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу угсрах ба газарт хөдөлгөөнгүй, бат бэх суурилуулна.
- 12.2 Тоног төхөөрөмжийг суурилуулах болон угсрахдаа үйлдвэрлэгчийн зааврыг чанд мөрдөнө.
- 12.3 Тоног төхөөрөмжийн холбох хэрэгслүүд нь бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байх ёстой бөгөөд үйлчлүүлж буй хүн гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.
- 12.4 Түгжээ, холбогч, хамгаалалтын бүрээс зэрэг нь бүрэн бүтэн, тусгай багаж хэрэглэхгүйгээр тайлж авах боломжгүй байх ба эрэг боолт бусад түгжих, бэхлэх зүйлс нь сулрах болон тайлагдахаас хамгаалагдсан байна.
- 12.5 Түгжээ, холбогч, хамгаалалтын бүрээс зэрэг нь урах, хатгах, хувцас тээглэх эрсдэл учруулахааргүй байна.
- 12.6 Хөдөлгөөнт холбоосны хийц нь сулрах, мултрахаас хамгаалагдсан анкер боолтоор бэхэлсэн байна.



Зураг 7. Түгжээ, холбогч, хамгаалалт, ил гарсан хэсгийн зөвшөөрөгдсөн хэмжээ /мм-ээр/

- 12.7 Бүх түгжээснүүд зэврэлтээс хамгаалагдсан байх ба холбогдсон эд ангийн зэврэлтийг хамгийн бага хэмжээнд байхаар материалыг сонгоно.
- 12.8 Тоног төхөөрөмжийг угсарсны дараа хэрэглээнд оруулахаас өмнө мэргэжлийн байгууллагаар аюулгүй байдал болон аюулгүй ажиллагааг хянаж баталгаажуулсан байна.
- 12.9 Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн төрөл, эдлэхүүний нийт жингээс хамааран суурийн бетон эдлэлийн болон суурилуулалтын гүн, хэмжээг тооцон суурилуулна.



Түлхүүр үг:
 1 Гол багана
 2 Гадаргуу
 3 Суурь

Зураг 8. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн суурилуулалтын жишиг зураг

13. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МАТЕРИАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 13.1 Гадна талбайн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн хийц бүтээц нь олон улсын чанарын шаардлага хангасан, эдэлгээ даахаар байх бөгөөд тоног төхөөрөмжийг олон улсын эрх бүхий үйлдвэрлэгчээс нийлүүлсэн байна.
- 13.2 Тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгч нь хэрэглэгч тоног төхөөрөмжтэй харилцсанаар тоног төхөөрөмжийг будсан, хамгаалсан химийн бодисоос хордохгүй, будаг нь чанарын шаардлага хангасан тухай баталсан байх шаардлагатай.
- 13.3 Монгол орны цаг уурын эрс тэрс нөхцөл байдалд зохимжтой, чийглэгт тэсвэртэй байхаар будагдсан материалтай байх ба байгаль орчинд хор нөлөөгүй материалаар хийгдсэн байна.
- 13.4 Тоног төхөөрөмжийн зааварт тоног төхөөрөмжийн материалын талаарх хэрэглэгчдэд хүргэх мэдээллийг тусгасан байна.
- 13.5 Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн эд зүйлд модон хийцээр хийгдсэн тохиолдолд хөрсний ялзралд тэсвэртэй модон материал сонгох бөгөөд модон хэсэглэлийг металл бэхэлгээ зэврүүлэх, ялзруулахаас хамгаалсан, эдэлгээг уртасгах зорилгоор ус чийг тусгаарлах зориулалт бүхий стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна.
- 13.6 Тоног төхөөрөмжийн металл хийц, хэсгүүд нь зэвэрдэггүй материалаар хийгдсэн байх. Зэврэх магадлалтай хэсгийг зэврэлтээс хамгаалах будаг, түрхлэгийг стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна.

14. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ АШИГЛАХ ЗААВАР БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ

- 14.1 Хэрэглэгчдэд өгөх дараах мэдээлэл болон санамжуудыг чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж дээр дараах зөвлөмж болон мэдээллийг тусган байрлуулсан байна. Үүнд:

- Тоног төхөөрөмжийг ашиглах насны хязгаар болон өндрийн хэмжээ. /1400 мм-ээс дээш өдөр/;
- Тухайн тоног төхөөрөмж дээр хийх дасгалын зааварчилгаа, зөвлөмжийн мэдээллийг зурган хэлбэрээр харуулах;
- Дасгалыг хэрхэн хийх дарааллыг үзүүлсэн байх;
- Дасгалыг хийснээр биеийн аль хэсэгт ачаалал өгөх талаарх мэдээллийг зурган хэлбэрээр үзүүлсэн байх;
- Тухайн тоног төхөөрөмжийн үндсэн зориулалт, үүргийн талаарх мэдээлэл;
- Аюулгүй байдлын мэдээлэл. Үүнд хориглох зүйлсийг тусгасан байна. (Жишээ нь: Тоног төхөөрөмж дээр дасгал хийхдээ зориулалтын хувцастай байх, хувцаснаас илүү гарсан сул хэсэг, уяа, ханцуй зэргийг орооцолдохоос сэргийлэх гэх мэт.)
- Тоног төхөөрөмжийг ашиглахад биеийн жингийн зөвшөөрөгдсөн дээд хязгаар;



Зураг 9. Тоног төхөөрөмж дээрх санамж, мэдээллийн хэсэг

- 14.2 Чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмж дээрх мэдээллээс гадна талбайн орох хэсэг эсвэл аль нэг хэсэгт мэдээллийн самбар байрлуулсан байна.
- 14.3 Самбарт хэрэглэгчдэд өгөх зөвлөгөө, заавар, дүрэм, санамж, сануулга, анхааруулга зэрэг мэдээллүүдээс тусгасан байна.
- 14.4 Хэрэглэгчдэд өгөх санамж, аюулгүй байдлыг хангах, мэдээллийн хэсгийг Зураг 10-т үзүүлэв.




Зураг 10. Хэрэглэгчдэд зориулсан талбайн мэдээллийн самбар

- 14.5 Чийрэгжүүлэх талбай, тоног төхөөрөмжийг эзэмшигч болон хариуцагч байгууллагад үйлдвэрлэгчээс ирүүлсэн тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ, материалын чанар зэргийн талаарх бүхий л мэдээлэл байх шаардлагатай.
- 14.6 Чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмж дээр эсвэл мэдээллийн самбар дээр хариуцагч байгууллагын нэр, хаяг болон холбоо барих утасны дугаарыг заавал байршуулсан байна.
- 14.7 Чийрэгжүүлэх талбай, тоног төхөөрөмжийн ашиглалтад эвдрэл гэмтэл гарах, эвдэн сүйтгэсэн зэрэг мэдээллийг мэдээлэх хэсэгт байгаа холбогдох байгууллагын хаяг, утасны дугаараар мэдэгдэнэ.

15. ЧИЙРЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙ НЭМЭЛТ ТОНОГЛОЛ

- 15.1 Чийрэгжүүлэх талбайн ойролцоо нийтийн эзэмшлийн сандал, хогийн сав байрлуулж болох ба хэрэглэгчдийн нягтаршил, эрчмээс шалтгаалан тоо хэмжээг тооцон байршуулна.
- 15.2 Нийтийн эзэмшлийн сандал нь UCS 1404C:2020 баримт бичгийн шаардлагыг хангасан байна.
- 15.3 Чийрэгжүүлэх талбайд хогийн сав байрлуулах бол талбайн гадна талд байршуулна.
- 15.4 Хогийн савыг байрлуулахад UCS1403C:2020 баримт бичгийн шаардлагыг хангасан байна.
- 15.5 Гэрэлтүүлэг нь хот суурин газар, барилга байгууламжийн орчны өнгө төрхөд ихээхэн нөлөөлдөг учир зураг төсөл гүйцэтгэхээс эхлүүлэн архитектур дизайны үзэл баримтлалтайгаар төлөвлөнө.



Зураг 11. Нэмэлт гэрэлтүүлэг бүхий чийрэгжүүлэх талбай

- 15.6 Гэрэлтүүлгийн ган баганыг суурилуулахдаа чийрэгжүүлэх талбайн хэмжээ, тоног төхөөрөмжийн байршил зэргийг анхаарах шаардлагатай.
- 15.7 Гудамжны архитектур, гоо зүйг бий болгох үүднээс гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн шон, толгой, хүзүү нь гудамжны бусад тавилгатай өнгө, загвар, дизайнтай уялдсан байна.
- 15.8 Гэрэлтүүлгийн төрөл ангилал, ган багана, өнгө, суурилуулах техник зэргийг Монгол улсын үндэсний стандарт “Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага” MNS2568-ийг мөрдлөг болгон “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага” UCS 1901B -ийн дагуу хийж гүйцэтгэвэл зохино.

16. АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ, ХЯНАЛТ


- 16.1 Чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийн бохирдол, элэгдэл, эвдрэлээс шалтгаалан иргэдэд осол гэмтэл учруулж болзошгүй нөхцөл байдлыг үнэлж байнгын хяналт, үнэлгээ хийж цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.
- 16.2 Нийтийн эзэмшилд байрлуулсан, чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийг хариуцагч байгууллага бүртгэх бөгөөд нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэх, ашиглах журмыг мөрдлөг болгоно.
- 16.3 Нийтийн эзэмшлийн чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийн элэгдэл болон эвдрэлээс шалтгаалан иргэдэд осол гэмтэл учруулах болзошгүй нөхцөл байдлыг үнэлж байнгын хяналт, үнэлгээ хийж цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.
- 16.4 Нийтийн эзэмшлийн чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийг зүй бусаар ашиглах, хохирол учруулах, сүйтгэх, устгах, гэмтээх, зүй зохисгүйгээр ашиглахыг хориглоно.
- 16.5 Чийрэгжүүлэлтийн талбай, тоног төхөөрөмжид хяналт, үнэлгээ хийх үзүүлэлтийг Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн хяналт, үнэлгээ хийх үзүүлэлт

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Тоног төхөөрөмж бохирдолтой байгаа эсэх	☐	☐
2	Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ хийгдсэн эсэх	☐	☐
3	Тоног төхөөрөмж нь эвдэрч гэмтсэн, хугарсан эсэх	☐	☐
4	Тоног төхөөрөмжийн будаг болон гадаргуу хэсэг ховхроогүй, бүтэн эсэх	☐	☐
5	Тоног төхөөрөмжийн холбоос болон төмөр хэсэг нь зэвэрсэн эсэх	☐	☐
6	Тоног төхөөрөмж болон түүний эргэн тойрон дахь талбайд хурц үзүүртэй зүйл байгаа эсэх	☐	☐
7	Талбайн гадаргуу хэсэг цэвэр, эвдэгч гэмтсэн эсэх (нүх үүссэн, ховхорсон, халцарсан, гадаргуу нь нэгэн жигд бус)	☐	☐
8	Тоног төхөөрөмжүүд бүрэн ажиллагаатай байгаа эсэх	☐	☐
9	Тоног төхөөрөмжийн бэхлэгээ найдвартай, зааврын дагуу хийгдсэн эсэх	☐	☐
10	Тоног төхөөрөмж дээрх зааварчилгаа болон мэдээлэл тодорхой харагдаж байгаа эсэх	☐	☐
11	Бэхлэгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан эсэх	☐	☐
12	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	☐	☐
13	Талбайн цэвэрлэгээ хангалттай хийгдсэн эсэх	☐	☐
14	Тоног төхөөрөмж дээр дасгал, хөдөлгөөн хийхэд бүрэн ажиллаж байгаа эсэх	☐	☐
15	Чийрэгжүүлэлтийн талбайн орчин аюулгүй эсэх	☐	☐

Тайлбар: Тоног төхөөрөмж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.


17. ЧИЙРЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЖИШИГ ЗАГВАР



Зураг 12. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар-1



Зураг 13. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар-2



Зураг 14. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-1



Зураг 15. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-2



Зураг 16. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-3



Зураг 17. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-4



Зураг 18. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-5

18. ЧИЙРЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

19.1 Чийрэгжүүлэх талбай, тоног төхөөрөмжийн материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 5.) -ийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 5. Хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Чийрэгжүүлэх талбай төлөвлөлтийн дагуу хийгдсэн эсэх	☐	☐
2	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг зөв байрлалд, зөв байршуулсан эсэх	☐	☐
3	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн заавар, стандартын шаардлагын дагуу суурилуулсан эсэх	☐	☐
4	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн зай хоорондын хэмжээ стандартад нийцэж байгаа эсэх	☐	☐
5	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж материалын чанарын шаардлага хангаж байгаа эсэх	☐	☐
6	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж модон хийц хэсгүүдэд байгалийн болон механик нөлөөллөөс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	☐	☐
7	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	☐	☐
8	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж нь гарал үүслийн гэрчилгээтэй эсэх	☐	☐

*Тайлбар: Чийрэгжүүлэх талбай, тоног төхөөрөмж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “**Тийм**” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “**Үгүй**” хэсгийг тэмдэглэнэ.*

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. EN 16630:2015 (E)- Permanently installed outdoor fitness equipment – Safety requirements and test methods
2. Park Fitness equipment plan City of Sydney 2030
3. Guidelines for planning installing and activating outdoor fitness equipment /State of Victoria, Department of Health and Human Services June, 2018./
4. <https://outdoorfitnessequipment.com.au/>
5. <https://greatoutdoorgym.com/about-great-outdoor-gym/>



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар